

**АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**НЭГ. ЗОРИЛГО**

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2017 оны а/552 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу сумдын Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
- Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ:

- Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
- Төрийн алба, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийг чадавхжуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт
- Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ:

- Байгууллагын ил тод, шударга байдлын үнэлгээ
- Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ
- Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцоходоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт нийт үнэлгээний 60 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 3 үзүүлэлт 20 хувиар тус тус тооцсон болно.

**ГУРАВ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД  
АНХААРАХ АСУУДАЛ, ЧИГЛЭЛ, ЗӨВЛӨМЖ**

### **3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**

-Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тогтмол гардаг шийдвэр, заалтыг тухай бүр нь хяналтаас хасах

-Тайланг гаргахдаа үр дүн, үр нөлөөг сайтар тооцоолж тайлагнадаг байх. Тайланд нийтлэг гарч байгаа дутагдал нь зарим тохиолдолд маш нуршуу бичигдсэн, зарим тохиолдолд хэтэрхий товчилж агуулга гаргаагүй байхад үнэлгээг маш өндөр дүгнэдэг. Иймд тайлангийн чанарыг сайжруулах, тайланг нэгтгэх, дүгнэх ур чадварт албан хаагч бүрийг сургах, чадавхжуулах

-Гүйцэтгэл сайжруулах болон байгууллагын дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлэх

-Шийдвэрийн биелэлтийг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, биелэлтийн байдалтай танилцах, хэрэгжилт, үр дүнг тооцон тодорхой шийдвэр гаргах, хянах, баталгаажуулах үүргийг сумын Засаг дарга хүлээнэ. Зарим сумдын хувьд тайланг уншиж, танилцахгүйгээр гарын үсэг зурж баталгаажуулдаг дутагдал байна.

### **3.2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар:**

-Засгийн газрын тогтоолын дагуу тайлагнахад анхаарч, үйл явц тоочиж хэт нуршуу бичсэн, бодит үр дүн, тоо, график ашиглах шаардлагатай.

-Зарим сумдын хувьд хэрэгжилт, үр дүнг хэт товч бичиж агуулга тодорхой гараагүй, сүүлийн 4 жилээр үр дүнд тулгуурлан бичиж тайлагнаагүй зэрэг дутагдал байсаар байна.

-Танилцуулгыг ойлгомжтой нэгтгэх, өмнөх оны мэдээлэл, судалгаан дээр үндэслэсэн тоон мэдээлэлд тулгуурлах,

- Үр дүнд тулгуурлах, харьцуулах, бодит гүйцэтгэлтэй уялдуулж үнэлэх шаардлагатай байна.

-Салбар бүрийн мэдээллийг нэгтгэж тусгасан сайн талтай. Гэвч зарим заалтын хэрэгжилтийн үр дүн, тоо, чанар анхаараагүй, ерөнхий үнэлсэн байна.

### **3.3.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт**


#### *Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд:*

-Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлагналт хэт ерөнхий байгаагаас үүдэн тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бодлогын ямар өөрчлөлт гарсан, нийгэмд үзүүлэх эерэг нөлөө зэргийг дүгнэх боломжийг хязгаарлаж байна.

-Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх.

-Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг журмын хавсралтад заасан маягтын дагуу тайлагнахгүй байна. Иймд цаашид Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлагнаж байхыг анхаарах.

-Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 5 бүлэг, 102 зорилт, 255 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан. Үр дүнгүй буюу 0 хувьтай үнэлэгдсэн 4 заалт гэж тайлагнасан боловч аль салбарын ямар арга хэмжээг 0 хувиар дүгнэсэн эсэх нь тодорхой байна.

A screenshot of a table with multiple columns and rows, likely representing a performance report or budget breakdown. The table is partially obscured by a watermark and is difficult to read in detail, but it appears to have several columns for different categories and rows for specific items or goals.

-Үнэлгээний нэгтгэлээс харахад үнэлэх боломжгүй 16 заалт гэж тайлагнасан боловч тайлангаас харахад үнэлэх боломжгүй 19 заалт байгаа нь зөрүүтэй мэдээлэгдсэн байна. Мөн хэрэгжилтийн дунджийг бодохдоо алдаа гаргасан. Дүнгийн хүснэгтээс харахад дундаж үнэлгээ 95.8 хувьтай гарахаар байхад хэрэгжилтийн дунджийг 96.02 хувьтай гэж тайлагнасан бөгөөд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх тухай” 2/07 дугаартай тогтоолоор уг үнэлгээг баталгаажуулсан байна. Иймд цаашид дээд шатны байгууллагуудад зөрүүтэй мэдээлэл өгөхгүй байх, үнэн зөв мэдээллээр хангаж, нэг ойлголт мэдээлэлтэй байхад анхаарах.

### Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд

-Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг холбогдох журмаар батлагдсан маягтын дагуу тайлагнаагүй.

-Холбогдох журмын дагуу зорилт, арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан бодитой үнэлэх шаардлагатай байна. Арга хэмжээний биелэлтийг гаргахдаа зорилтот түвшинтэй уялдуулан гаргаагүй, мэдээлэл дутуу, үнэлгээг бодит бус, өндөр үнэлсэн байна.

-Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу нөхцөл байдлын шинжилгээ, тооцоо судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэр, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бодитой хэрэгжих, үнэлэх боломжтойгоор боловсруулж байх шаардлагатай байна.

### **3.4. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт**

-Үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хяналтад авч, журмын дагуу үнэлсэн.

-Зарим хөтөлбөрийг бодит бус хэт их өндөр үнэлсэн.

-“Соёлын үйлдвэрлэл”, “Хоршоог хөгжүүлэх”, Төрийн албан хаагчийн сургалт-хөгжил”, “Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх хөтөлбөр”, “Нэг өрх-Нэг ажлын байр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Жендер-ӨВ дэд хөтөлбөр”, “Аймгийн хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”, “Эрчим хүч хэмнэх”, “Цахим-Архив” зэрэг аймгийн хөтөлбөрийн биелэлтийг ирүүлээгүй. Мөн тайлангийн чанар, үр дүнд анхаарах.

### **ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ:**

#### **4.1. Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт**

-Байгууллагынхаа албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан үнэн зөв, товч тодорхой тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэх

-Гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гэрээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон болон чанарын шалгуурыг хэрхэн хангасан тухай үр дүнд тулгуурлан тайлагнах

-Ажил зохион байгуулах төлөвлөгөө гаргаж ажилласан бол төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж тайланд дурдах, төлөвлөгөөний дагуу ямар ажил зохион байгуулж ажилласан тухай товч, тодорхой тайлагнах

-Хяналт шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, зохион байгуулсан ажлыг товч, тодорхой үр дүнг тайлагнах

-Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах

#### **4.2. Төрийн алба, архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийг чадавхжуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт**

##### *Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийг чадавхжуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт:*

-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу мэдээллийг үнэн зөв, бүрэн тайлагнах

-Холбогдох мэдээ, судалгааг ирүүлэхдээ тухай бүр заасан хугацаанд үнэн зөв, бүрэн, тайланд хамгийн гол үр дүн, ахиц өөрчлөлтийг бодит, хэмжигдэхүйц байдлаар товч бөгөөд тодорхой тайлагнахад анхаарах

-Төрийн албан хаагчийн ёс зүй, мэдлэг, хандлага, үр чадварыг дээшлүүлэх чиглэлээрх ажил, арга хэмжээний үр нөлөө, үр дүнг үнэлэхэд бодит өөрчлөлтийг бий болгоход анхаарах

-Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийг чадавхжуулах талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг бататган төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангахад тайлант онд хүрсэн түвшинг цаашид үе шаттай ахиулах нь зүйтэй.

##### *Төрийн алба, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт:*

-Төрийн алба, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын талаарх холбогдох хууль, журмууд 2020 онд шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг шинэчлэгдсэн эрх зүйн актуудад нийцүүлэх ажлыг 2021 оноос тодорхой төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх. Тухайлбал Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” гэх мэт.

-Байгууллага болон төсөвт байгууллагын албан хаагчдынхаа төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөгдөх хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стандарт зааврын талаарх мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоодын сургалтыг тодорхой төлөвлөгөөтэй, үр дүнтэй зохион байгуулж хэвших

-Архив, албан хэрэг хөтлөлтийн тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнахдаа үйл ажиллагаа, арга хэмжээний гол үр дүн, ахиц өөрчлөлтийг товч бөгөөд тодорхой тайлагнаж хэвших

-Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ирүүлэхдээ албан хэрэг хөтлөлтийн стандартыг сайтар хангуулан тайлагнаж хэвших.

## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ:

### 5.1. Байгууллагын ил тод, шударга байдлын үнэлгээ

#### Ил тод байдлын үнэлгээний хүрээнд:

-Ил тод байдлын хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүнд суурилж, тодорхой, статистик тоо баримтад тулгуурлан тайлагнах

-Сумын цахим хуудас 9 цэс, 24 дэд цэстэй бөгөөд үүнээс 22 дэд цэсэд мэдээлэл байршуулсан. Мэдээллийн ихэнх нь 2019 онд тавигдсан учир сайтад тавигдах шаардлагын дагуу баяжилт хийж, мэдээ мэдээллээ бүрэн байршуулах.

-Иргэдэд мэдээлэл илүү хүртээмжтэй хүргэх сувгуудыг ашиглах

-Мэдээллийг ил тод байдлыг хангах чиглэлээр хийгдсэн ажлуудын нийт төсвийг тайлагнах


#### Шударга байдлын үнэлгээний хүрээнд:

Авлигатай тэмцэх газраас тавьж буй шаардлагын хүрээнд сумын шударга байдлыг үнэлэхдээ авлигын эсрэг үйл ажиллагаа, АТҮХөтөлбөрийн орон нутагт хамаарах заалтын хэрэгжилтийн тайлан болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын албан ёсны цахим сайтдаа байршуулбал зохих мэдээллүүдийг байршуулсан эсэх гэсэн үндсэн 2 шалгуур үзүүлэлтийг үндэслэн, тайлангийн биелэлт 80 хувь, сайтад мэдээлэх үйл ажиллагааг 20 хувь нийт 100 хувь байхаар дүгнэв.

Тухайлбал төрийн байгууллагууд цахим сайтдаа тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, өмнөх оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, холбогдох хууль тогтоомж, томилогдсон албан тушаалтны ХАСУМ дүгнэлт, авлигад өртөх эрсдэл бүхий албан тушаалтны жагсаалт, холбогдох гарын авлага материал, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр байршуулбал зохих мэдээллийг байршуулсан зэрэг байдлыг харгалзав.

2020 оны шударга байдлын үнэлгээнд нийт 19 сум, 22 агентлаг хамрагдахаас 19 сум, 18 агентлаг хамрагдаж, сумдын Засаг даргын Тамгын газрын нийт дундаж 81.8 хувийн биелэлттэй дүгнэгдлээ.

**Зураг 1. Сумын шударга байдлын үнэлгээний нийт дунджийг 2019 болон 2020 оноор, хувиар харьцуулахад:**



Үүнийг өмнөх онтой харьцуулан үзэхэд сумдын дундаж үнэлгээ 2019 онд 78.8 хувь байсан бол 2020 онд 81.8 хувь болж 3 хувиар өссөн байна.

Сумдын дундаж үнэлгээ 3 хувиар өссөн харагдаж байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шийдвэрийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа сайжирч, холбогдох тайлан мэдээний ирц, чанар ахисан үзүүлэлттэй байна.

Сумдаас 4 сум хангалттай маш сайн буюу “А”, 8 сум хангалттай сайн буюу “В”, 7 сум хангалттай буюу “С” үнэлгээтэй тус тус үнэлэгдсэн байна.

### Хүснэгт 1. Сумдын шударга байдлын үнэлгээ оноор, хувиар.

№	Байгууллагын нэр	Шударга байдлын үнэлгээ /хувиар/		Өссөн, буурсан үзүүлэлт /хувиар/
		2019 он	2020 он	
1	Арвайхээр	80,8%	82.0%	+2.8%
2	Бат-Өлзий	78,0%	80.0%	+2%
3	Баруунбаян-Улаан	80,0%	88.0%	+8%
4	Баян-Өндөр	70,0%	70.0%	=
5	Баянгол	72,4%	75.0%	+2.6%
6	Богд	72.0%	70.0%	-2%
7	Бүрд	85,0%	88.0%	+3%
8	Гучин-Ус	80,0%	75.0%	-5%
9	Есөнзүйл	74,4%	75.0%	+0.6%
10	Зүүнбаян-Улаан	81,0%	85.0%	+4%
11	Нарийнтээл	85,6%	88.0%	+3.6%
12	Өлзийт	70,0%	70.0%	=
13	Сант	85,8%	90.0%	+5%
14	Тарагт	80.0%	87.0%	+7%
15	Төгрөг	72,0%	75.0%	+3%
16	Уянга	85.0%	90.0%	+5%
17	Хайрхандулаан	78,0%	90.0%	+8%
18	Хархорин	78,0%	88.0%	+10%
19	Хужирт	90,0%	90.0%	=
	<b>Дундаж хувь</b>	<b>78.8%</b>	<b>81.8%</b>	<b>+3.0 %</b>

Нийт байгууллагуудын 80.9 хувь нь иргэдийг мэдээллээр хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох чиглэлээр олон төрөлт мэдээллийн сувгийг бүрэн ашиглаж, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд алдаа дутагдал, илэрсэн зөрчлийг арилгах ажлуудыг байгууллага бүр гүйцэтгэл сайжруулах болон байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн нь гол үр дүнд хүрэх хөшүүрэг болсон байна.

Тухайлбал сумдаас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын цахим сайтдаа байршуулж, мэдээллэх үйл ажиллагаа өмнө жилээс ахисан байна. Энэ нь 2019 онд 5 сум цахим хуудсандаа авлигын чиглэлээр мэдээлэл оруулсан байсан бол 2020 онд 14 сум авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цэс нээж, тодорхой мэдээллүүдийг байршуулсан байна. Мэдээлэл оруулаагүй 5 сум байна /Баянгол, Баян-Өндөр, Богд, Гучин-Ус, Есөнзүйл/.

Дээрх сумдууд нь байгууллагын цахим сайтдаа авлигын чиглэлээр цэс нээж, тодорхой мэдээллүүдийг байршуулсан хэдий ч нийтлэг дараах алдаа дутагдал байна. Тухайлбал урд оны мэдээллээ шинэчлээгүй, үүсгэсэн цэсний нэр болон байршуулсан мэдээлэл зөрүүтэй, ач холбогдолгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан, цэс үүсгэж мэдээлэл байршуулсан

гэх боловч АТГазрын болон шилэн данс, холбогдох яамны сайтыг шууд холбосон зэрэг мэдээллийн шинэчлэл, баяжилт хангалтгүй байна.

## **5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ**

-Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулж буй мэдээллийн үнэн зөв байдал, цаг хугацаанд нь оруулахыг сайтар анхаарч байх.

-Сарын мэдээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлантай яг тохируулж нэгдсэн цахим хуудсанд тавьж байх.

-Өр авлагын талаарх тайлбар болон төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тухай тайлбарыг товч бөгөөд тодорхой оруулах.

-Мэдээлэл хоцорч орж байгаа тохиолдол байгаа тул улирлын тайлан илгээлтийг системийн ачааллыг тооцоолон 2 хоногийн өмнөөс эхлэн тайланг илгээсэн байхаар мэдээллийг оруулж байх.

-Өөрчлөлт ороогүй мэдээлэлд "Төсвийн тодотгол ороогүй" "Үнэ тарифт өөрчлөлт ороогүй" гэх мэтээр ойлгомжтой товч бичиж байх.

-Тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч солигдсон тохиолдолд шинээр томилогдсон албан тушаалтны үндсэн мэдээлэл, холбоо барих дугаар зэргийг цаг алдалгүй сольж байх зэрэгт анхаарах шаардлагатай.

## **НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай холбогдуулан хүргүүлж буй дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлыг уялдаа холбоотой зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах,

Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн удаашралтай байгаа болон хэрэгжилт тасарч байгаа зорилт, заалтуудыг өмнөх онуудтай харьцуулсан дүгнэлт хийх, үйл явцыг бус үр дүнг чухалчлах, график, хүснэгт ашиглах зэрэг тайланг энгийн ойлгомжтой хэлбэрт оруулах байдалд ахиц гаргах шаардлага байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад харагдаж байна. Тайлагналт хэт ерөнхий байгаагаас үүдэн тухайн шийдвэр, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бодлогын түвшинд ямар өөрчлөлт гарсан, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг дүгнэх боломжийг хязгаарлаж байгааг анхаарах.

Тодорхой шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй байгаа зорилт, арга хэмжээ, шийдвэр, заалтын хэрэгжээгүй шалтгааныг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг хэлэлцэн, тухай бүр шийдвэрлэж байх асуудал сул байна.

Томоохон бодлогын баримт бичгүүд тухайлбал аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг тайлагнахдаа тухайн арга хэмжээний хүрсэн түвшин нь өнгөрсөн оноос хэрхэн өссөн, буурсан, яаж сайжруулсан гэх мэт мэдээлэл дутмаг байгаагаас тодорхой бус, үйл явц тайлагнах байдал байсаар байна. Иймд зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, шалгуур үзүүлэлтээ хангасан эсэх, зорилтод түвшин, бодит үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой тайлагнадаг арга барилд бүх албан хаагчдаа сургах шаардлагатай байна.

Цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ач холбогдлыг төрийн байгууллагуудад таниулах, мэдээлэл, солилцох үйл ажиллагааг тогтмолжуулж, албан хаагчдын баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт нотолгоонд тулгуурлан тайлагнахад анхаарахын зэрэгцээ байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулан, Засгийн газрын 2011 оны "Нийтлэг журам батлах тухай" (ААНБ-ын дотоод

хяналт шалгалт) 311 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2012 оны “Журам батлах тухай” а/84 дүгээр захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах нь зүйтэй байна.

--oOo--